

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/027/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@gmail.com
	Б энд С аудит ХХК-ийн Захирал Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: Info@bcauditllc.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14

№ 01/315

танай _____-ны № _____-г

ГЕОДЕЗИ УСНЫ, БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БЯМБАСАЙХАН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Жаргалантын амны үерийн хамгаалалтын барилга байгууламж, угсралтын ажлыг 2022-2024 онд үе шаттайгаар хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явцад Дата төвийн шилэн кабель таарсан, Шүүх шинжилгээний газрын хашаа таарч сувгийн трассд өөрчлөлт орсон, ухлагын гүн нэмэгдсэн, газар чөлөөлөлттэй холбоотой зэрэг асуудлуудаас шалтгаалан ажил зогсож 1,120.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Улаанбаатар хотын захирагчийн албатай байгуулсан 2024 оны 24/03-21 дугаар гэрээ, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын НТ-22-А/281-НӨ дугаар гэрээ, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн санхүүжилт шийдвэрлэх тухай А/62 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын А/1009 дугаар захирамж зэргийг үндэслэн 4,127.7 сая төгрөгийн шууд худалдан авалт, тухайн захирамжтай холбоотой сонгон шалгаруулалт зарлахгүйгээр аж ахуйн нэгж байгууллагаас 725.4 сая төгрөгийн худалдан авалт, 609.9 сая төгрөгийн ажил үйлчилгээг түрээсийн гэрээгээр хийж гүйцэтгэсэн байна.

Бусад асуудал

Санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгагдаагүй Сэлбэ голоос баруун уулын төгсгөл хүртэлх шугам угсралт, засвар, сувгийн цэвэрлэгээ зэрэгт Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 145.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Засаг даргын нөөц сангаас 2,526.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АУОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,254,696,089.61	2,155,538,998.74
1.1.2	Дансны авлага	4,177,789.95	17,103,827.00
1.1.4	Бусад авлага	175,000,000.00	50,000,000.00
1.1.6	Бараа материал	631,520,141.98	1,456,383,844.83
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,065,394,021.54	3,679,026,670.57
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	82,741,685,319.09	76,825,673,660.69
1.2.2	Биет бус хөрөнгө	321,504,000.00	321,504,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	83,063,189,319.09	77,147,177,660.69
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	85,128,583,340.63	80,826,204,331.26
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	39,932,703.97	46,522,499.00
2.1.1.3	Татварын өр	91,194,969.46	196,702,127.35
2.1.1.4	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг		735,180.30
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	374,892,000.00	374,892,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	22,879,901,293.64	20,358,880,783.05
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	23,385,920,967.07	20,977,732,589.70
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	23,385,920,967.07	20,977,732,589.70
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	84,502,272,373.94	84,502,272,373.94
2.3.2	Хувийн өмч		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	928,987,463.11	928,987,463.11
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	321,504,000.00	321,504,000.00
2.3.10	Хуримтлагдсан ашиг	(24,010,101,463.49)	(25,904,292,095.22)
2.3.11	Эздийн өмчийн дүн	61,742,662,373.56	59,848,471,741.83
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	85,128,583,340.63	80,826,204,331.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,856,716,125.52	18,739,260,257.77
2	Борлуулалтын өртөг	7,154,015,528.72	11,088,710,003.33
4	Нийт ашиг (алдагдал)	348,101,047.56	7,650,550,254.44
6	Хүүгийн орлого	11,746,330.45	
8	Бусад орлого	1,050,801,644.36	3,538,440,510.59
11	Ерөнхий ба удирдлагын зардал	3,884,730,617.95	5,909,472,500.41
13	Бусад зардал	84,771,650.00	96,827,875.17
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-11,324,855.56	
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,317,181,840.62)	(1,894,190,631.730)
20	Орлогын татварын зардал		
21	Татварын дараах ашиг (алдагдал)	(4,317,181,840.62)	(1,894,190,631.73)
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,317,181,840.62)	(1,894,190,631.73)
23.3	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
25	Орлогын нийт дүн	(4,317,181,840.62)	(1,894,190,631.73)
26	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	84,502,272,373.94	928,987,463.11	321,504,000.00	(19,692,919,622.87)	66,059,844,214.18
2	Өмчид гарсан өөрчлөлт					
3	Тайлант үеийн үр дүн				(4,317,181,840.62)	(4,317,181,840.62)
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	84,502,272,373.94	928,987,463.11	321,504,000.00	(24,010,101,463.49)	61,421,158,373.56
8	Тайлант үеийн үр дүн					-
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	84,502,272,373.94	928,987,463.11	321,504,000.00	(24,010,101,463.49)	61,742,662,373.56
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	84,502,272,373.94	928,987,463.11	321,504,000.00	(24,010,101,463.49)	61,421,158,373.56
17	Тайлант үеийн үр дүн				(1,894,190,631.73)	(1,894,190,631.73)
18	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	84,502,272,373.94	928,987,463.11	321,504,000.00	(25,904,292,095.22)	59,848,471,741.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,401,639,148.00	16,781,748,305.73
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,390,211,196.36	16,770,772,042.73
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,365,188.00	8,008,063.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,062,763.64	2,968,200.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,791,709,560.92	15,779,574,696.60
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,119,273,194.03	3,925,816,440.73
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	663,879,586.35	984,536,836.97
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,898,097,547.92	5,566,137,186.21
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	845,947,902.37	977,207,640.50
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	657,209,911.30	1,288,772,757.67
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		3037103835
1.2.9	Бусад мөнгөн зарлага	607,301,418.95	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	609,929,587.08	1,002,173,609.13
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,746,330.45	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	11,746,330.45	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	435,002,588.03	276,330,700.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	435,002,588.03	276,330,700.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(423,256,257.58)	(276,330,700.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	25,512,627.00	175,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	25,512,627.00	175,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,512,627.00	175,000,000.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	212,185,956.50	900,842,909.13
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,042,510,133.11	1,254,696,089.61
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,254,696,089.61	2,155,538,998.74

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2024 он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийслэлийн Захирагчийн Ажлын Алба /цэвэрлэгээ/	10,344,950.0	10,167,894.7	177,055.3	98.3
1	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ ашиглалт	2,314,000.0	2,298,278.8	15,721.2	99.3
2	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар арчлалт	5,145,950.0	4,903,431.9	242,518.1	95.3
3	Авто замын борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээ үйлчилгээ ашиглалт	2,340,000.0	2,272,686.4	67,313.6	97.1
4	Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний засвар арчлалт	60,000.0	58,930.3	1,069.7	98.2
5	Борооны болон хөрсний ус зайлуулах өргөлтийн насос станцын ашиглалт, засвар үйлчилгээ	380,000.0	471,442.3	(91,442.3)	124.1
6	Мониторингийн цооногийн ашиглалт, засвар үйлчилгээ	105,000.0	103,125.0	1,875.0	98.2
7	Далан, сувгийн цэвэрлэгээнд шаардагдах	-	60,000.0	(60,000.0)	
1	Нийслэлийн Замын Хөгжлийн газар санхүүжилт	350,000.0	175,000.0	175,000.0	50.0
1	Авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажил	350,000.0		350,000.0	-
2	Барьцааны авлага		175,000.0	(175,000.0)	
1	Нийслэлийн Засаг даргын тамгын газар	4,255,416.2	2,294,127.8	1,961,288.3	53.9
1	ХУД Жаргалантын амны үерийн хамгаалалтын барилга байгууламж ажил	4,255,416.2	2,294,127.8	1,961,288.3	53.9
1	Өөрийн орлого	209,090.9	387,305.3	(178,214.3)	185.2
2	Бусад орлого		231,789.7	(231,789.7)	
1	ИТХ-аас Тоног төхөөрөмж худалдан		145,800.0	(145,800.0)	
2	ЗДТГ-аас Эрдэнэтолгой		390,000.0	(390,000.0)	
3	Сэлбэ баруун уулын төгсгөл /Далан цэвэрлэгээ/		1,553,952.3	(1,553,952.3)	
4	Шугам засвар /5-н шар		29,950.0	(29,950.0)	
5	Хойшлогдсон орлого буюу үнэ төлбөргүй шилжүүлж авсан хөрөнгийн элэгдэл		3,538,440.5	(3,538,440.5)	
1	Нийт орлогын дүн	15,159,457.1	18,739,260.2	(3,579,803.2)	123.6
2	Цалин	5,858,926.1	3,622,105.4	2,236,820.7	61.8
2.2	Хоол унааны хөнгөлөлтийн зардал	379,192.0	288,871.0	90,321.0	76.2
2	НДШ 15.5%	1,171,785.2	984,536.8	187,248.4	84.0
2	Удирдах зөвлөлийн зардал	53,935.2	42,100.0	11,835.2	78.1
3	Ашиглалтын зардал	75,266.4	47,941.4	27,325.0	63.7
3	Үндсэн хөрөнгийн элэгдэл	5,262,088.6	5,352,503.2	(90,414.6)	101.7
3	Түүхий эд материал	4,624,323.2	4,311,669.0	312,654.2	93.2
3	Даатгал	26,972.1	23,602.8	3,369.3	87.5
3	Шатахуун	884,983.2	689,140.9	195,842.3	77.9
2	Тээвэр	171,000.0	930,465.9	(759,465.9)	544.1
2	Тос, тосолгооны зардал	83,521.3	38,064.7	45,456.6	45.6
2	Машин механизмын сэлбэг хэрэгсэл	307,789.0	152,494.5	155,294.5	49.5

2	Хангамжийн материал	64,278.8	63,924.5	354.3	99.4
2	Хөдөлмөр хамгаалал, багаж хэрэгсэл	133,119.0	126,561.9	6,557.1	95.1
2	Ажлын хувцас	141,855.0	140,254.6	1,600.4	98.9
2	Шуудан холбоо	12,496.0	12,010.4	485.6	96.1
2	Бичиг хэрэг	36,460.0	28,352.4	8,107.6	77.8
2	Албан томилолт	51,000.0		51,000.0	
2	Шагнал урамшуулал	65,000.0	33,293.0	31,707.0	51.2
2	Тэтгэмж	37,500.0	39,481.3	(1,981.3)	105.3
2	Сургалт	36,900.0	1,250.0	35,650.0	3.4
2	Албан татвар	3,500.0	6,397.1	(2,897.1)	182.8
2	Газрын төлбөр	3,011.4	3,029.4	(18.0)	100.6
2	Нийгмийн арга хэмжээний зардал	72,000.0	72,000.0		100.0
2	Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх зардал	50,000.0	35,846.4	14,153.6	71.7
2	Урсгал засвар, засвар үйлчилгээний зардал	53,000.0	4,358.2	48,641.8	8.2
2	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	438,000.0	3,255,240.3	(2,817,240.3)	743.2
2	Гаднын үйлчилгээний зардал	8,000.0		8,000.0	
2	Бусад зардал	9,000.0	51,624.9	(42,624.9)	573.6
2	Эрсдэлийн сан	15,000.0		15,000.0	-
	Нийт зарлагын дүн	20,381,862.6	20,633,450.8	(251,588.2)	101.2
3	Татварын өмнөх ашиг	(5,222,405.5)	(1,894,190.6)	(3,328,214.9)	36.3
4	Цэвэр ашиг алдагдал	(5,222,405.5)	(1,894,190.6)	(3,328,214.9)	
5	Нийт авлага	181,497.1	50,360.6	131,136.5	27.7
6	Нийт өр төлбөр	414,824.7	613,960.7	(199,136.0)	148.0
7	Хөрөнгө оруулалт	251,960.0	276,330.7	(24,370.7)	109.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 114,099.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
И-баримт шивүүлээгүй 58,750.3 мянган төгрөгийн худалдан авалтыг нөхөн шивүүлсэн	1	58,750.3			1	58,750.3	1	58,750.3				
Үндсэн хөрөнгийн элэгдэл 55,348.9 мянган төгрөгөөр илүү байгуулсан алдааг залруулав.	1	55,348.9			1	55,348.9	1	55,348.9				
Дүн	2	58,750.3			2	58,750.3	2	58,750.3				

Аудитаар нийт 143,069.7 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс 1,002.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 116,722.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 25,344.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага Тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АШ	Тоо	Дүн
Цалин хөлсийг олгохдоо гарсан тушаал шийдвэр, цагийн балансад үндэслэж олгоогүйгээс 1.0 сая төгрөгийн цалин илүү олгосон	1	1,002.8	1	1,002.8								
Барьцаа дансны өглөгийн үлдэгдэл 29.3 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	29,325.0			1	29,325.0						
11 аж ахуйн нэгж болон 8 иргэнээс худалдан авсан бараа ажил үйлчилгээнд ибаримт	1	25,344.5					1	25,344.5				

шивүүлж баримтаар зардлыг бүрэн нотлоогүй												
Тайлант жилд тендер зарлахгүйгээр 87,397.4 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн	1	87,397.4			1	87,397.4						
Дүн	4	143,069.7	1	1,002.8	1	116,722.4	1	25,344.5				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 65,406.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага Тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АШ	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаалаар ажилчдад дархлаа дэмжих нэрээр мах, гурил, будаа, хэвийн боов, еэвэн, ааруул зэрэг нийт 49.8 сая төгрөгийн тэтгэмжийг хавтгайруулан тараасан	1	49,770,0			1	49,770,0						
Цалин хөлсийг олгохдоо ажилд орсон, ажлаас гарсан тушаалын өдрөөр тасалбар болгоогүй, цагийн балансад үндэслэж олгоогүй, тушаалын хэрэгжилт хангалтгүй	1	15,636.3			1	15,636.3						
Дүн	2	65,406.3			2	65,406.3						